



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/876

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь хэсэг, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 44 дүгээр тушаалын 2 дахь заалт, 49 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын Ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилгын гадна тохижилтын ажил ИНЕГ/УТ/ТББ/А-05/18 /Багц-1/, Нисэх буудлын үйлчилгээний барилгын гадна тохижилтын ажил ИНЕГ/УТ/ТББ/А-05/18 /Багц-2/ дугаар гэрээт ажлуудыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:	Г.Мөнхболд	Нисэх буудлуудын удирдах газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	П.Сүхболд	Худалдан авах ажиллагааны тасгийн аэродромын инженер
Гишүүд:	О.Алтантариа	Улаанбаатар хотын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны Барилга байгууламж, засвар арчлалтын хэсгийн ахлах инженер
	Э.Мөнх-Эрдэнэ	Улаанбаатар хотын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны аэродромын ашиглалтын инженер
	Г.Даваасүрэн	Улаанбаатар хотын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны аэродромын ашиглалтын инженер
	Я.Пагмаажав	Төв аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн зам, тээвэр, мэдээлэл холбооны асуудал хариуцсан бодлогын мэргэжилтэн /тохиролцсоноор/
	С.Эрдэнэцогт	Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн /тохиролцсоноор/

2. Дээрх ажлыг Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журмын дагуу шалган хүлээн авах комиссын акт холбогдох бусад материалыг бүрдүүлж, Худалдан авах ажиллагааны тасагт хүргүүлэхийг комиссын дарга /Г.Мөнхболд/-д даалгасугай.

ДАРГА { Л.БЯМБАСҮРЭН



The image shows a red rectangular official stamp. The stamp contains the following text: 'Уулсүрэн, Хөвсгөл аймгийн Засаг дарга', 'Хүндэтгэсэн', '2013.08.06', 'Худалдан авах ажиллагааны тасаг', and 'Л.Бямбасүрэн'. There is a handwritten signature over the stamp. A bracket on the left side of the stamp is labeled 'ДАРГА', and a bracket on the right side is labeled 'Л.БЯМБАСҮРЭН'. A large oval is drawn around the stamp and the labels.